



АСГАТ СУМЫН  
СОНГУУЛИЙН ХОРООНД

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2024.08.08 № 445  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн (Н.Дашдондог)-ий сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, ТЕЗ-ийн дунд хугацааны төсвийн

хүрээний мэдэгдэл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч иргэн (Н.Дашдондог)-ий сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Мөрийн хөтөлбөр ( ..... хуудас)-ийг хавсаргав.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

СҮХБААТАР АЙМГИЙН АСГАТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
2024 ОНЫ СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ НАНЗАД ОВОГТОЙ  
ДАШДОНДОГИЙН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Нэр дэвшигч: Нанзад овогтой Дашдондог

Миний бие 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөр боловсруулахад, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37.6 дахь хэсэгт заасны дагуу дараах бодлогыг баримталсан болно.

1. *Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030*
2. *“Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого*
3. *Сүхбаатар аймгийн хөгжлийн хэтийн зорилт 2020-2028*

#### 1. ЭДИЙН ЗАСГИЙН ТАЛААР

1.1 Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл хоршоог дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэн иргэдийн аж ахуй эрхлэх санал санаачлалыг дэмжиж аж ахуйн эрхлэлтийн сургалтад хамруулна.

1.2 Шинээр ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлнэ.

1.3 Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй, ил тод, шуурхай байдлыг хангуулахад хяналт тавьж ажиллана.

#### 2. БОЛОВСРОЛ

2.1 Сургуулийн чанар, хүртэмж хүүхэд сургах орчныг сайжруулах бодлого боловсруулан ажиллана.


2.2 Сургууль цэцэрлэгийн хүүхдүүдийн ая тухтай сурч хүмүүжих тал дээр тоглоом наадгай сургалтын хэрэглэгдхүүний хангамж, гадна тоглоомын талбайг сайжруулах талаар дэмжиж ажиллана.

2.3 Сургууль цэцэрлэгийн чанартай боловсрол эзэмшүүлэхэд багш нарыг мэргэжил дээшлүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран дэмжиж ажиллана.

#### 3. ЭРҮҮЛ МЭНД

3.1 Эрүүл мэндийн анхан шатны болон нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

3.2 Иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, тэдний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхийг дэмжиж ажиллана.





3.3 Нийтийн биеийн тамир, спортыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлэх, хүн амын амьдралын зөв хэв маяг, эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэн ажиллахад анхаарна.

#### 4. БАЙГАЛЬ ОРЧИН ГАЗАР АШИГЛАЛТ

4.1 Бэлчээрийг зохистой ашиглах, сайжруулах, хамгаалах талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх талаар бодлого боловсруулж ажиллана.

4.2 Тэр бум мод хөдөлгөөний хүрээнд айл өрх байгууллагуудад мод тарих орчноо зүлэгжүүлэх хөдөлгөөн өрнүүлж сумын төвүүдийн ногоон байгууламжийн талбайг 2 дахин нэмэгдүүлнэ.

4.3 Хүлэмжийн аж ахуйг эрхлэх жимс жимсгэнэ төмс хүнсний ногоо тариалах иргэдийг дэмжиж ажиллана.

4.4 Хог хаягдалгүй орчинд амьдрах орчин бүрдүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ажил зохион байгуулна.

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ

*Н. Дашдондог* Н.ДАШДОНДОГ

Холбоо барих утас: 99259669

РД:85091810